

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2014 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2014 оны 07 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын тогтоол шийдвэр, Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2014 онд хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааг чиглүүлж, дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

Нэг. Дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх талаар:

Шинэчлэн батлагдсан хууль тогтоомж болон бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэгтэй уялдуулан байгууллага, алба хаагчдын ажил үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, иргэд, олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэж, ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд:

Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлалын төслийг боловсруулан Хууль зүйн яаманд хүргүүлж, 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Улсын Их Хурлаар батлуулсан.

Цагдаагийн албаны тухай хууль, дагалдан нэмэлт, өөрчлөлт орсон бусад хуулиуд болон шинэчилсэн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэгт нийцүүлэн алба хаагчдын үйл ажиллагааг жигдрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөн үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна.

Цагдаагийн төв байгууллагын шинэ бүтцийн тухай танилцуулга, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Хууль зүйн яаманд хүргүүлснээр Засгийн газрын 2013 оны 405 дугаар тогтоолоор цагдаагийн төв байгууллагын орон тооны дээд хязгаар, Хууль зүйн сайдын 2013 оны А/266, А/276 дугаар тушаалуудаар Цагдаагийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг тус тус батлуулсан.

Үүний дагуу “Цагдаагийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын цол, цалингийн зэрэглэлийг батлах тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 755 дугаар тушаалаар харьяа нэгжүүдийн бүтэц, орон тоо, албан тушаалын цол, цалингийн зэрэглэлийг баталсан.

Нийслэлийн цагдаагийн газрын бүтцэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгж байгуулах асуудлыг судалж, Цагдаагийн ерөнхий газрын даргын “Нийслэлийн цагдаагийн газрын бүтэц, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг батлах тухай” 2014 оны 71 дүгээр тушаалаар тус газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын бүтцэд “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс”-ийг офицер 18, ахлагч 6, энгийн 8, нийт 32 орон тоотой байгуулсан.

Нийслэлийн цагдаагийн газрын Хүүхэд хамгаалал, хаяг тогтоох төвийг татан буулгаж, үйл ажиллагааны чиглэлийг Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг “Түр хамгаалах байр” болгон өөрчилж, 8 өрөөнд урсгал засвар хийж тохижуулахад

41.0 сая төгрөг зарцуулж, 02 дугаар сарын 28-ны өдрөөс үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

“Цагдаагийн байгууллагын талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Цагдаагийн байгууллагын зарим үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ыг үндэслэн хүн амын нягтаршил, эрүү, хэв журмын нөхцөл байдлыг харгалзан Сонгинохайрхан дүүрэгт цагдаагийн 3 дугаар хэлтсийг шинээр байгуулж, Баянзүрх дүүрэгт гуравдугаар хэлтсийг байгуулахаар Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар ажлын хэсэг томилон ажиллуулж, холбогдох тооцоо судалгааг хийн, дүүргийн Засаг даргатай уулзаж, тус хэлтсийн байрны асуудлыг шийдвэрлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч байна.

Нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан жишиг нормативын дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 313, 399 дугаар тушаалаар зарим аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн бүтцэд дараах өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

- Увс аймаг дахь цагдаагийн газрын Хотгорын уурхай дээр хэсгийн байцаагч 2, бүгд 2 офицер, Баянхонгор аймаг дахь цагдаагийн газрын Гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн “ахлах мөрдөн байцаагч 1”, “Бууцагаан сум дахь сум дундын цагдаагийн хэсгийн дарга”, “мөрдөн байцаагч 1” цагдаа-зохицуулагч 1, цагдаа-жолооч 1 бүгд 4, Дорнод аймаг дахь цагдаагийн газрын Матад суманд сум дундын цагдаагийн хэсэгт 3 офицер, 2 ахлагч, бүгд 5, Дундговь аймаг дахь цагдаагийн газарт хэсгийн байцаагч 1, замын цагдаагийн байцаагч 1, хэрэг бүртгэгч 1 бүгд 3, Дорноговь аймаг дахь цагдаагийн газарт хэсгийн байцаагч 1, замын цагдаагийн байцаагч 1, хэрэг бүртгэгч 1 бүгд 3, Ховд аймаг дахь цагдаагийн газрын Булган сум дахь цагдаагийн хэлтэст эрүүгийн төлөөлөгч 1, замын цагдаагийн байцаагч 1, бүгд 2, Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсэгт мөрдөн байцаагч орон тоог тус тус шинээр нэмсэн.

- Баянхонгор аймаг дахь Бууцагаан, Дорнод аймаг дахь цагдаагийн газрын Матад сумдад сум дундын цагдаагийн хэсгийг шинээр байгуулж, Булган аймаг дахь цагдаагийн газарт Зам тээврийн хяналтын төвийг шинээр барьж ашиглалтад оруулсантай холбогдуулан хяналтын постод 4 цагдаа-зохицуулагч, аймгийн төвийг камержуулсантай холбогдуулан камерын хяналтын төвд 4 цагдаа, 1 сүлжээний инженер бүгд 1 офицер, 8 ахлагч орон тоог шинээр нэмсэн.

Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хуульд нийцүүлэн дотоодын цэргийг цагдаагийн байгууллагад шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, Засгийн газрын 2014 оны 108 дугаар тогтоолын дагуу Дотоодын цэргийн 05, 805, 809, 810, 811, 816 дугаар анги болон орон нутгийн салбаруудыг татан буулгаж, хугацаат цэргийн 283 алба хаагчдыг холбогдох зардлын хамт Хил хамгаалах ерөнхий газрын 0151, 0164, 0288 ангиудад шилжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар, Хууль зүйн сайдын дангаар болон хамтран батлах, Цагдаагийн ерөнхий газрын даргын батлах эрх зүйн баримт бичиг, Хууль сахиулах үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, Цагдаагийн албаны тухай хуулийг дагалдан гарсан хуулиудтай холбогдуулан хэрэгжилтийг хангах календарчилсан төлөвлөгөө /5 бүлэг, 38 ажил, арга хэмжээ/-г хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж байна. Тухайлбал:

-“Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр батлах тухай”, “Цагдаагийн алба хаагчид мөнгөн урамшил олгох журам батлах тухай”, “Цагдаагийн төв байгууллагын орон тооны дээд хязгаарыг батлах тухай”, “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай”, “Цагдаагийн байгууллагын хамгаалалтад авах онц чухал объектын жагсаалт батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоол;

-“Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай”, “Цагдаагийн ахлах цол олгох болон түүнтэй адилтгах албан тушаалын ангилал, зэрэглэлийг батлах тухай”, “Цагдаагийн алба хаагчийн тангараг өргөх ёслолын журам батлах тухай”, “Цагдаагийн албаны тугны загвар, түүнийг хэрэглэх журам, бэлэг тэмдгийн загварыг батлах тухай”, “Цагдаагийн албан тушаалын цол олгох журам батлах тухай”, Иргэний зөвлөлийн дүрэм, Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журам батлах тухай Хууль зүйн сайдын тушаал;

-“Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм, Цагдаагийн хүрээний дүрэм батлах тухай”, “Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм батлах тухай”, “Олон нийтийн цагдаагийн ажилтны таних тэмдэг, хөдөлмөр аюулгүй байдлын хувцас өмсөж хэрэглэх журам, хувцасны загвар батлах тухай”, “Олон нийтийн цагдаагийн ажилтны хөдөлмөрийн гэрээ, ажил дүгнэх үзүүлэлт, үнэмлэхний загвар батлах тухай”, “Галт зэвсэг хадгалах, хамгаалах, бүртгэх, тавьж олгох журам батлах тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалууд батлагдсан.

Засгийн газрын 2014 оны “Цагдаагийн алба хаагчдын талаар авах зарим арга хэмжээний тухай” 99 дүгээр тогтоолоор цагдаагийн алба хаагчдын цалингийн нэмэгдлийг шинэчлэн батлуулсан.

2013 онд Сангийн яамнаас баталсан цагдаагийн байгууллагын орон тооны хяналтын тоог 8962 орон тоотой байхаар баталж өгсөн бөгөөд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн хүрээнд 4064 офицер, 4133 ахлагч, 564 энгийн, нийт 8761 алба хаагчийн орон тоотой ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын шинэтгэлийн бодлогын хүрээнд хийгдсэн бүтэц орон тооны өөрчлөлтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 105 дугаар тушаалаар харьяа нэгжүүдийн чиг үүргийг тодорхой болгон тогтоож, албан тушаалын нэр, нэршлийг тодорхойлох, ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, нийт 737 ажлын байрны тодорхойлолтыг баталгаажуулсан.

Ухаалаг төрийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилгоор 2014 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын харьяа албад, газар, хэлтсийн удирдах бүрэлдэхүүн, мөн албад, газар, хэлтэс, төвийн алба хаагчдын дунд хэлэлцүүлэг зохион явуулсан.

Хэлэлцүүлгийн үеэр алба хаагчдын гаргасан санал, санаачилга, шийдвэрийг үндэслэн цагдаагийн байгууллагад ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлэх чиглэлээр 6 бүлэг, 39 заалттай ажлын төлөвлөгөө боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулж, 2014 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 3а/547 дугаар албан

бичгээр төв, орон нутгийн цагдаагийн газар хэлтэст хүргүүлэн биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны газраас хэрэгжүүлж буй “Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, зардал багатай хүргэх “Цахим болон мобайл технологид суурилсан програм хангамжийн нэгдсэн үйлчилгээний портал систем хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвөөс үзүүлж буй /тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох, жолоодох эрх сэргээх, үнэмлэх нөхөн олгох, жолоочийн үнэмлэх солих, гадаадын иргэнд жолооны үнэмлэх сольж олгох, жолоочийн лавлагаа гэсэн/ 6 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хэсэгт алба хаагчид ажиллаж байна.

“Тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх”, “Ан агнах, уралдаан тэмцээнд оролцох” зорилгоор галт зэвсгийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг авахад бүрдүүлэх материал, цахим машинаас олгоход үүсэх хүндрэл, эрсдлийн талаар танилцуулга, мэдээлэл бэлтгэн Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны газарт хүргүүлсэн.

Мөн Хууль зүйн сайдын 2013 оны А/130 дугаар тушаалаар батлагдсан “Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор ШШГЕГ-ын даргын 2014 оны А/72 дугаар тушаалаар байгуулагдсан шүүхээр тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ялаар шийтгэгдсэн ялтны жолооны үнэмлэхийг улирал тутам устгах ажлын хэсэгт 2 алба хаагч томилогдон ажиллаж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ялаар шийтгэгдсэн 1249 ялтны жолооны үнэмлэхийг устгах ажлыг 2 удаа гүйцэтгэж, 183 жолоочийн жолоодох эрхийн үнэмлэхийг ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газарт шилжүүлсэн.

Жолоочийн мэргэжлийн шалгалт авах үйл ажиллагааг боловсронгуй болгох, замын хөдөлгөөний дүрмийн шалгалтыг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох журам”-ын дагуу онолын шалгалтыг 10 асуулт бүхий тестийг 15 минутад, 20 асуулт бүхий тестийг 25 минутад тус тус багтааж бөглөх байдлаар авах цахим программыг боловсруулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 63 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн Цагдаагийн байгууллагын бодлого, үйл ажиллагааны стратеги зорилго, зорилтыг тодорхойлж, 2014-2019 онд 2 үе шаттай хэрэгжүүлэх “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулан Засгийн газрын 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 79 дүгээр тогтоолоор батлуулсан.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдын бие бялдарын төвшинг тогтоох, мэдээллийн нэгдсэн сан байгуулах зорилгоор төв, орон нутгийн цагдаагийн 64 газар, хэлтэс, төвийн 6285 алба хаагчийн биеийн жингийн индексийн судалгааг авч нэгтгэн мэдээллийн сан байгуулсан.

“Бие бялдарын бэлтгэлжилтийг тодорхой түвшинд байлгах, биеийн зохист харьцааг тогтоох сургалт явуулах тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 135 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, 18-30 насны хэт таргалттай 1477 алба хаагчаас 24 алба хаагчийг сонгон авч, 3 сар сургалтад хамруулав.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 104 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2014 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу 25 төрлийн 231 удаагийн сургалт зохион байгуулж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 6677 алба хаагчийг сургалтад хамруулсан.

Мэргэшүүлэх чиглэлээр нийт 343 сэдвээр 1252 цагийн сургалт зохион явуулж, 3346 алба хаагч хамрагдав.

БНСУ, АНУ, ИБУИНВУ, ХБНГУ, Тайланд, ОХУ, Канад, Австрали, Катар, Малайз, Филиппин зэрэг 21 улсад зохион байгуулагдсан сургалт семинарт 22, хурал, зөвлөгөөн, уулзалтад 10, албан томилолтоор 12, туршлага судлах, үзэсгэлэн үзэх 30, нийт 74 алба хаагчийг гадаадад томилолтоор ажиллуулсан.

Удирдлагын академиас зохион явуулсан “Төрийн байгууллагын албан хэрэг, хөтлөлт, стандарт” сэдэвт 16 цагийн сургалтад 3 алба хаагч, Сургалт дадлагын төвд зохион байгуулагдсан 3 хоногийн сургалтад харьяа газар, хэлтсийн нийт 36 алба хаагчийг хамруулав.

Алба хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, сургалтын шинэлэг орчинг бүрдүүлэх зорилгоор “Сантис” сургалтын төвтэй хамтран англи хэлний 3 шатны сургалтад 54 алба хаагчийг хамруулсан.

Алба хаагчдын ур чадварыг дээшлүүлэх гадаад сургалтад 3.7, дотоодын сургалтад 64.6 сая төгрөг зарцууллаа.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын ажлын талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Цагдаагийн байгууллагаас 2014 онд авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөнд 113 ажил, арга хэмжээг тусган батлуулж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлэн, биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Шинэ бүтцийн дагуу зохион байгуулагдсан газар, хэлтсүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар “Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм”, “Цагдаагийн хүрээний дүрэм”, “Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм” /34/, “Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дүрэм” /190/, Нийтийн хэв журам хамгаалах болон Гэмт хэрэгтэй тэмцэх газар, Хуулийн хэлтэс, Хэвлэл, мэдээллийн, Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны, Сургалт, дадлагын төвийн дүрмийг боловсруулан /302 дугаар тушаалаар/ батлуулж, холбогдох, газар, хэлтэс, төвүүдэд албан бичгээр хүргүүлэн мөрдөж байна.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай”, “Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай”, “Терроризмтэй тэмцэх тухай”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх”, “Зар сурталчилгааны тухай”, “Нийтийн албаны тухай”, “Галт зэвсгийн тухай” хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд төв, орон нутгийн цагдаагийн газраас санал авч нэгтгэн боловсруулж, Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 388 дугаар тогтоолоор баталсан “Бэлэн бус торгуулийн систем нэвтрүүлэх түр журам”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр

зохион байгуулалтын арга хэмжээ авч, Нийслэлийн Замын цагдаагийн газар 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдөр шалгах болон хэвлэх 400 ширхэг төхөөрөмжийг хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж эхэлснээс хойш 2014 оны эхний хагас жилд нийт 213419 зөрчил илрүүлж, 1.6 тэрбум төгрөгийн торгууль ногдуулсан.

Замын цагдаагийн алба хаагчид шалгах болон хэвлэх төхөөрөмжийг ашигласнаар цагдаагийн байгууллагын ASAP санд бүртгэлтэй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс эрэн сурвалжлагдаж байсан 189 этгээдийг илрүүлэн холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын хүний нөөцийн холбогдолтой 118 тушаал батлагдан гарснаас бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр 4727, шилжүүлэн томилсон 386, цагдаагаас офицерын бүрэлдэхүүнд орсон 23, офицер, дадлагажих ажилтнаар томилогдсон 12 алба хаагч байна.

Тайлангийн хугацаанд нийт 240 алба хаагчийг албан тушаал дэвшүүлэн томилсноос газар, хэлтэс, төвийн даргаар 25, дэд даргаар 3, тасаг, хэсгийн даргаар 26, нөөцөөс ахлах албан тушаалд 112 алба хаагч томилогдсон.

Орон нутгаас нийслэлд 37, нийслэлээс орон нутагт 13 алба хаагчийг шилжүүлэн, хүүхэд асрах чөлөө цуцалсан 23, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн 3, түдгэлзүүлснийг цуцалсан 3, албан тушаал бууруулан томилсон 55 тушаал тус тус гаргасан.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр өөрийн хүсэлтээр 15, өөр албанд 73, гачигдлаар 8, бүтэц, орон тооны өөрчлөлтөөр 55, эмнэлгийн магадлагаагаар 9, сургуульд суралцуулахаар 13, хүүхэд асрах чөлөөгөөр 41, тэтгэвэрт гаргахаар 58 алба хаагчийг ажлаас чөлөөлж, данс бүртгэлээс 4 алба хаагчийг хасч, дутагдлаар 21 алба хаагчийг албанаас халсан байна.

Эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажилласан алба хаагчдаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар алтан гадас одонгоор 2, Цэргийн гавъяаны одонгоор 6, Цэргийн хүндэт медиалаар 31, Шударга журам медиалиар 1, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хууль зүйн тэргүүний ажилтан” цол, тэмдгээр 4, “Цагдаагийн алдар” хүндэт тэмдгээр 38, “Хүндэт жуух”-аар 4, Цагдаагийн ерөнхий газрын “Цагдаагийн гавьяа” тэмдгээр 231, “Хүндэт жуух бичиг”-ээр 119, “Спортын алдар” тэмдгээр 4, “Цагдаагийн төлөө тэмдэг”-ээр 9 алба хаагчийг шагнаж, урамшуулав.

Үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 21 алба хаагчийг албанаас дутагдлаар халж, 87 алба хаагчид цолны нэмэгдлийг хасахаар, 260 алба хаагчийн цалинг тодорхой хувиар бууруулах сахилгын шийтгэл оногдуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 07 дугаар тушаалаар Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах, Замын цагдаа, Нийгмийн хэв журам хамгаалах, Хэрэг бүртгэх газар, Дотоод цэргийн штабын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийг Төв архивт шилжүүлэх ажлын хэсэг байгуулан ажиллуулж, эрүүгийн цагдаагийн газраас байнга хадгалах 41, түр хадгалах 331, Нийгмийн хэв журам хамгаалах газраас 2011-2013 байнга хадгалах 21, хувийн хэрэг 14, 1995-2014 оны түр хадгалах 5854, Дотоодын цэргийн штабаас 1990-2013 оны байнга хадгалах 3 28, түр хадгалах 323, 175 хувийн хэрэг, нууцын зэрэглэлтэй 95 материал,

Дотоодын цэргийн 811 дүгээр тусгай салбараас 2006-2013 оны байнга хадгалах 6 хадгаламжийн нэгжийг шилжүүлэв.

Хууль зүйн яамнаас “Хуульчдын талбай”-д 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдах “Нээлттэй өдөрлөг”-т оролцох алба хаагчдын ажлын чиглэл, цагийн хуваарийг батлуулж, бэлтгэл ажлыг хангах талаар Нийслэлийн цагдаагийн газар, Гэмт хэрэгтэй тэмцэх газар, Дэмжлэг үзүүлэх газрын харьяа газар, хэлтэс, төвийн дарга нарт албан бичиг хүргүүлэн, өдөрлөгт Цагдаагийн ерөнхий газрын 14, Нийслэлийн цагдаагийн газрын 2 алба хаагч оролцон, цагдаагийн алба хаагчтай холбоотой 2, хүний нөөцтэй холбоотой 1 өргөдөл хүлээн авч, 8 иргэнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилан, санамж сэрэмжлүүлэг тарааж, www.mass.mn, www.medee.mn, www.eagle.mn цахим сайт, Монголын мэдээ, Зууны мэдээ, Өдрийн шуудан сонин, SBN, Eagle, NBS, Star, ЭКО, Эх орон телевиз зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан ажиллав.

2014 оны эхний хагас жилийн байдлаар иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 310 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлснийг бүртгэн, холбогдох газар, хэлтэс, төвд албан бичгээр хүргүүлж, хариуг авч шийдвэрлэсний 150 буюу 48.4 хувь нь санал хүсэлт, 111 буюу 35.8 хувь нь гомдол, 19 буюу 6.1 хувь нь талархал, 27 буюу 8.7 хувь нь шүүмжлэл, 3 буюу 0.9 хувь нь өргөдөл байна.

Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 302 буюу 97.4 хувийг шийдвэрлэж, 8 буюу 2.6 хувь нь ажиллагаанд байгаа ба чанараар нь авч үзвэл 242 буюу 78.1 хувийг 5 хоногийн дотор, 60 буюу 19.3 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэжээ.

2014 оны эхний 6 сард иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 583 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 271 нэгж буюу 86.8 хувиар өсч, 620 алба хаагч холбогдсоны 428 буюу 69.0 хувь нь офицер, 187 буюу 30.1 хувь нь ахлагч, 5 буюу 0.8 хувь нь сонсогч бүрэлдэхүүн байна. Нийт өргөдөл гомдлын 560 буюу 90.3 хувийг барагдуулж, 24 буюу 3.8 хувийн үлдэгдэлтэй байна.

Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 44 буюу 7.5 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 120 буюу 20.6 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 17 буюу 2.9 хувь нь хэргийн хугацаа хэтэрсэн, 46 буюу 7.9 хувь нь бусдыг чирэгдүүлж танил тал харсан, 133 буюу 22.8 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 7 буюу 1.2 хувь нь хээл хахууль шан харамж авсан, 33 буюу 5.6 хувь нь бусдыг зодож эрх чөлөөнд нь халдсан, 80 буюу 13.7 хувь нь ажлын хариуцлага алдсан, 26 буюу 4.4 хувь нь архидан согтуурсан, 10 буюу 1.7 хувь нь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 63 буюу 10.8 хувь нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль дүрэм зөрчсөн, 2 буюу 0.3 хувь нь цалин, тэтгэвэр тэтгэмж буруу тогтоосон, 2 буюу 0.3 хувь нь төсвийн хөрөнгө ашигласан зөрчлүүд эзэлж байна.

Сахилгын арга хэмжээ авагдсан байдлыг авч үзвэл: Эрүүгийн хэрэг үүсгэхээр шилжүүлсэн 14, албанаас халсан 17, цол бууруулсан 1, цалин бууруулсан 171, цолны нэмэгдэл хассан 3, сануулсан 41, алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нотлогдоогүй 326, нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан 19 байна.

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн “Хоногийн нөхцөл байдлын мэдээ”, анхаарал татсан гэмт хэргийн талаар мэдээлэл бэлтгэн Монгол Улсын Ерөнхий сайд, Хууль зүйн сайдад нийт 26 удаа, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик дүн мэдээнд үндэслэн улсын хэмжээний эрүү, хэв журмын нөхцөл байдалд сар бүр дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлаар Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн даргад 3 удаа танилцуулсан.

Цагдаагийн байгууллагын 6626 алба хаагчдын 2013 онд мэдүүлсэн хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч, нэгтгэн тайланг хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад анх орох болон албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 374 алба хаагчийн урьдчилсан мэдүүлэгт дүгнэлт гаргуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Гурав. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилтийн талаар:

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж, 2014 оны эхний хагас жилд дараах ажлыг гүйцэтгэв.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр: Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн даргын ахалсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах мэргэжлийн удирдлагаар хангах дэд зөвлөлтэй хамтран Азийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Мөн ДОХ-ын халдвар авсан иргэд болон БХЗӨ-өөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт бүлгийг тогтоох зорилгоор биеэ үнэлэгч эмэгтэйчүүдийн нас, хаяг байршил зэрэг шаардлагатай мэдээллээр цахим сан үүсгэх талаар Эрүүл мэндийн яаманд албан бичиг хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн тагнуулын газартай хамтран БНХАУ-аас “Ардын уламжлалт тан” гэх халхавчаар мансууруулах, сэтгэц нөлөөлөх бодисыг хилээр нэвтрүүлэн ОХУ-руу гаргаж байж болзошгүй этгээдүүдийг илрүүлэх “Алтан үрэл” тусгай арга хэмжээ явуулж, мэдээлэл солилцон ажиллаж байна.

2014 оны 04 дүгээр сарын 16-наас 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналтад тавих тухай” хэрэгжилтийг хангах зорилгоор тэсрэх, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлодог, үйлдвэрлэдэг, тэсэлгээний ажил эрхэлдэг 101 аж ахуйн нэгжийг хамруулсан хяналт шалгалт зохион явуулж, дүнг Уул уурхайн сайдад танилцуулсан.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, ялангуяа хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, ан агнуур, ойн тухай хууль тогтоомж зөрчих зэрэг гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой сэжигтэй этгээдүүдийн гэмт үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох, нотлох баримтын эх сурвалжийг тогтоох зорилгоор

1035.5 сая төгрөгийн хохиролтой, 22 холбогдогчтой, 15 гэмт үйлдлийг баримтжуулан шалгаж, эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр холбогдох цагдаагийн газар, хэлтсийн Мөрдөн байцаах албанд шилжүүлсэн.

Улсын хэмжээнд уул уурхайн чиглэлээр ашиглан эвдэгдэж, орхигдсон газрын судалгаан дээр дүн шинжилгээ хийж, 2014 оны 03 дугаар сарын 15-наас 2014 оны 04 дүгээр сарын 25-ны хооронд “Эвдэгдсэн газар” нэгдсэн арга хэмжээг зохион явуулж, 20 аймгийн 703 нэгж бүхий 4320.5 га талбай уул уурхайн олборлолтоос болж эвдэрснийг тогтоон, 6 үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалт явуулж, 37 аж ахуйн нэгж дээр шалгалтын ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

Өвөрхангай аймгийн Уянга сумын “Бөөрөлжүүт” хэмээх газарт “Шаазгай бадмаараг”, “Соёл арвижих”, “Шар зүлэг” зэрэг 11 компаниуд хууль бусаар алт олборлон байгаль орчинд 625.0 сая төгрөгийн хохирол учруулсан хэргийг илрүүлж, мөрдөн байцаалтын ажиллагааг дуусган прокурорт шилжүүлсэн байна.

Алтны далд наймаатай тэмцэх зорилгоор Тагнуулын ерөнхий газартай хамтран “Улаан Жамсран” арга хэмжээ зохион явуулж, хууль бусаар алт хил нэвтрүүлсэн 2 гэмт хэрэг, 3 үйлдлийг илрүүлэн 11.49 кг цэвэр алтыг хураан авч, 800.0 сая төгрөгийг улсын орлого болгосон.

Алт, монет болон мөнгөн эдлэлийг гаалийн татвараас зайлсхийн хууль бусаар хил нэвтрүүлдэг этгээдүүдийг илрүүлэх зорилгоор “Шагай”, “Болор” арга хэмжээнүүдийг явуулж, Чингис хаан олон улсын нисэх буудлаар иргэн “А” 4 кг монетон эдлэл, 16 кг мөнгөн эдлэлийг гаалийн хяналтаас нуун хилээр нэвтрүүлсэн үйлдлийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 30.0 сая төгрөгийн гаалийн татварыг нөхөн төлүүлсэн.

Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр: Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалаар “Иргэний зөвлөлийн дүрэм”-ийг батлуулж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд хүргүүлж, Иргэний зөвлөл байгуулах ажлыг хамтран зохион байгуулах, туслалцаа дэмжлэг үзүүлэх, Иргэний зөвлөлтэй хамтран ажиллах ажилтныг томилох, дүрмийг нутаг дэвсгэрийн хэмжээнд болон иргэд, олон нийтэд сурталчлах чиглэлээр зөвлөмж өгч, аймаг, нийслэлийн хэмжээнд иргэний зөвлөлд нэр дэвших хүсэлтийг хүлээн авах зар тараах, нэр дэвшүүлэх, материалыг хүлээн авах зэрэг ажлуудыг зохион байгуулсан.

Аймаг, нийслэлээс иргэний зөвлөлийн гишүүдийн тоо, урамшууллын талаар санал авахад 11 аймгаас 75 гишүүн ажиллуулахаар төлөвлөж, нэг гишүүнд дунджаар 192.000-250.000 төгрөгийн урамшуулал олгох боломжтой гэсэн судалгаа ирүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 382, 383 дугаар тушаалаар “Олон нийтийн цагдаагийн ажилтны таних тэмдэг, хөдөлмөр аюулгүй байдлын хувцас өмсөж хэрэглэх журам”, “Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм”-ийг тус тус батлуулан, улсын нэгдсэн бүртгэлд оруулж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 424 дүгээр тушаалаар дээрх дүрмийн хэрэгжилтийг хангах, олон нийтийн цагдаагийн ажилтныг сонгон шалгаруулах, сургаж дадлагажуулах ажиллагааг удирдах, зохион байгуулах,

хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, олон нийтийн цагдаагийн ажилтныг бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, тэдэнтэй байгуулах хөдөлмөрийн гэрээний төслийг боловсруулах, урамшлын хэмжээг тогтоох, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Олон нийтийн цагдаагийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих” код, журмыг боловсруулж батлуулах, олон нийтийн цагдаагийн ажилтны анкет, хувийн хэрэг хөтлөх тухай зааварчлага, үнэмлэхний загвар, ажил дүгнэх үзүүлэлт, эрүүл мэндийн хуудасны үлгэрчилсэн загваруудыг гаргах зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.

Гадаадын жуулчдыг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн Засаг Даргын Тамгын газартай хамтран “Оюутан цагдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлж, их дээд, сургуулийн 83 оюутанг сонгон авч, 2 үе шаттай сургалтад хамруулан батламж өгч, 2014 оны 07 дугаар сараас 09 дүгээр сар хүртэл гэрээ байгуулан ажиллуулж байна.

Тээврийн хэрэгсэл жолоодож буй иргэд согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах Drager 7510, 9510 хэрэгслийг Монгол Улсын хэмжих хэрэгслийн бүртгэлд бүртгүүлэхээр Стандартчилал хэмжил зүйн газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн загварын туршилтын хурлаар хэлэлцүүлэн, Стандартчилал хэмжил зүйн газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/124 дугаар тушаалаар баталгаажуулж, OLML 126 / Олон улсын хууль эрхийн хэмжил зүйн байгууллага/ стандартын дагуу Стандартчилал хэмжил зүйн газраас 26 дугаар гэрчилгээ авсан.

2013 оны 11 дүгээр сараас 2014 оны 05 дугаар сар хүртэлх хугацаанд Сүхбаатар дүүргийн 1-16 дугаар хорооны нутаг дэвсгэрийн нийт 125 цэгт 252 ширхэг камер тавих ажлыг “Сектек сервис” ХХКомпани 814.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ба одоо тус дүүрэг дэх цагдаагийн 1,2 дугаар хэлтэс хяналтын камерыг туршилтын журмаар ажиллуулж байна.

2014 онд тус дүүргийн 20 хорооны 82 цэгт хяналтын камерыг гэрэлтүүлгийн хамт тавихад орон нутгийн төсвөөс 800.0 сая төгрөг батлагдсан бөгөөд тус дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор Тамгын газрын даргаар ахлуулсан судалгааны ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

2014 онд Сонгинохайрхан дүүргийн 32 хорооны нутаг дэвсгэрийн 161 цэгт 262 телекамерыг гэрэлтүүлгийн хамт тавихад нийслэлийн төсвөөс 1 тэрбум 600 сая төгрөгийн хөрөнгө батлагдсан бөгөөд 2014 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр тендерийн үнэлгээний хороо байгуулагдсан байна.

Хэнтий аймгийн төвийг камерын системд холбохоор 2013 онд орон нутгийг хөгжүүлэх сангаас 350.0 сая төгрөгийн хөрөнгө батлагдсан бөгөөд тендерт шалгарсан “Миротек” ХХКомпани нийт 41 ширхэг камер суурилуулах ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэн одоо улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.

2013 онд Булган аймгийн төвийн 33 цэгт 86 хяналтын камер тавихаар 639.0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэсэн ба гүйцэтгэгчээр “Тэргэл тех” ХХКомпани шалгарч уг ажлыг эхлүүлсэн боловч өвлийн улиралд түр зогсож одоо гүйцэтгэл 45 хувьтай байна. Энэ онд тус аймагт нэмж камер тавихад улсын төсвөөс 350.4 сая

төгрөг батлагдаж гүйцэтгэгчээр “Мон кабель” ХХКомпани шалгарч ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.

2014 онд улсын төсвөөс Орхон аймгийн төвд нэмж камер тавихад зориулж 400.0 сая төгрөг батлуулж, 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг орон нутагт нь зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 174,175 дугаар тушаалаар төв, орон нутаг дахь Дотоодын цэргийн тусгай салбар, салааг татан буулгаж, бие бүрэлдэхүүн, зэвсэг, техник хэрэгслийг орон тоо, данс бүртгэлээр нь харьяалах цагдаагийн газар, хэлтэст, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 108 дугаар тогтоолоор татан буугдсан 05, 805 дугаар ангийг Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын харьяанд шилжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 100 дугаар тогтоолоор татан буугдсан 8 объектыг харьяалагдах байгууллагын захиргаанд хүлээлгэн өгөх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 263 дугаар тушаалаар Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын Хамгаалалтын газрын бүтцэд “Тусгай хамгаалалтын хоёрдугаар хэлтэс”-ийг байгуулж, алба хаагчдыг шилжүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 409 дүгээр тушаалаар Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Бүгд Найрамдах Солонгос Улсын буцалтгүй тусламжаар баригдсан Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн “Яармагийн насос станцын байгууламжийг хүлээн авч, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын 805 дугаар /анги/ хэлтсээс хамгаалалтын харуулын 1 цэг байгуулан ажиллуулсан.

Мөн Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, “Чингис хаан” Олон Улсын нисэх буудлын онгоц хөөрөх, буух зурваст, Туул голын дагуу Нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдсан тэжээлийн 20 гүний худгийг хамгаалалтад авах талаар судалгаа хийж, Ус сувгийн удирдах газарт санал хүргүүлсэн.

Нийслэлийн цагдаагийн газрын Албадан саатуулах баривчлах төвийн баривчлах байрыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих 441 дүгээр ангийн байранд нүүлгэн шилжүүлэх, урсгал засвар хийх 48.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж, засварын ажлыг эхлүүлсэн.

Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 5 дугаар бүлгийн кодуудыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, “Олон нийтийн аюулгүй байдлыг хангах” /код 500/, “Төрийн болон гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үед хамгаалалт зохион байгуулах” /код 503/, “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах” /код 504/, “Жагсаал цуглааны үед олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах” /код 505/, “Нийтийг хамарсан арга хэмжээний үед хамгаалалт хийх” /код 507/, “Гамшигийн үеийн цагдаагийн байгууллагын ажиллагаа” /код 508/, “Зарим объектыг хамгаалалтад хүлээн авах, түр хугацаагаар хамгаалалтыг зохион байгуулах” /код 510/, “Онц чухал объектод гадаадын иргэнийг нэвтрүүлэх, түүнд хяналт тавьж, хамтран ажиллах” /код 512/, “Харуулын заавар боловсруулах, мөрдөж ажиллах” /код 514/, “Нууц үг батлах, дугаар

харьцах” /код 515/, “Галт зэвсэг, тусгай хэрэгслийг агуулахад мөрдөх” /код 523/ журмыг боловсруулсан.

Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн ерөнхий шаардлага MNS 5527:2005 стандартыг өөрчилж саатуулах байрны стандартыг шинэчлэн боловсруулж байна.

Эрүүл мэндийн сайдын “Эрүүлжүүлэх үйл ажиллагааг эмнэлгийн байгууллагуудад шилжүүлэх хүртэл архины хордлого тайлах зориулалтаар эмнэлгийн ор ажиллуулах, архины хордлого тайлах эмчилгээ үйлчилгээг нэгдсэн эмнэлгийн бүтэц, эмчилгээ үйлчилгээний стандартад нийцүүлэн чирэгдэлгүй үйлчлэх тухай” 2014 оны 1А/164 дүгээр албан бичгийг Нийслэлийн цагдаагийн газрын дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд хүргүүлж, ажлын чиглэл өгсөн.

Гадаадын зочин төлөөлөгчдийн 8, улс төрийн нам эвсэл холбоо, төрийн бус байгууллагуудаас зохион байгуулсан 19, Төрийн ёслол хүндэтгэлийн 37 удаагийн хэв журмын хамгаалалтын төлөвлөгөө зураглалыг батлуулж, хамгаалалтад Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын Хамгаалалтын газар, 05,805 дугаар анги /хэлтэс/, Нийслэлийн цагдаагийн газрын харьяа дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн 3162 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, Сүхбаатар аймгийн төв, Төв аймгийн Баянцогт суманд болсон хурдан морины уралдаан, Төв аймгийн Сүмбэр сумын “Гэр чулуу”, Говь-Алтай аймгийн Дэлгэрэх сум, Сэлэнгэ аймгийн Орхонтуул суманд цугларсан гар аргаар алт олборлогч иргэдийн бөөгнөрөл, “Босоо хөх монгол”, “Гал үндэстэн”, “Цөмийн энергийн эсрэг төв” зэрэг төрийн бус байгууллагаас Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Сүхбаатар аймгийн Онгон суманд зохион байгуулсан жагсаал, цуглаан, Увс аймгийн төвд болсон МУГЖ С.Жавхлангийн тоглолт, Баянхонгор аймгийн төв зохион байгуулагдсан өсвөрийн жудочдын улсын аварга шалгаруулах тэмцээн зэрэг нийт 134 удаагийн нийтийг хамарсан болон урлаг, соёлын арга хэмжээний хамгаалалтад 3853 алба хаагч 15926 хүн цагийн үүрэг гүйцэтгэсэн байна.

Сүхбаатар аймгийн Наран, Онгон, Дарьганга сум, Хэнтий, Дорнод, Дорноговь аймгуудад гарсан “А” хэвшлийн мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин, Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт иргэн М.Дамдинхүүгийн гахайн фермд гарсан “Гахайн үржил, амьсгалын замын хам шинж” өвчний голомт, нийт 101 цэгт хорио цээрийн дэглэм сахиулахаар 102 алба хаагч, 10 машинтай 65 хоног үүрэг гүйцэтгэсэн.

Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектод нэвтрэх 386019 хүн, 92056 тээврийн хэрэгсэл, 11758 вагон нүүрс, экспортод гаргах 43428 уут 2038 чингэлэг зэсийн баяжмал, 240 уут 25 чингэлэг молибдений баяжмал, лабораторид шинжлүүлэх 3053.6 кг зэсийн баяжмал, 475.2 кг молибдений баяжмал, 2873.5 тэсрэх бодисыг шалган нэвтрүүлж, хамгаалалтын бүсэд хийсэн хяналт шалгалтаар 121 зөрчил илрүүлж, 86 иргэнийг 430.0 мянган төгрөгөөр торгон захиргааны туслах тоо бүртгэлийн санд шивж оруулан, 29 иргэнийг холбогдох захиргааны байгууллагад нь мэдэгдэж, архи дан согтуурсан 7 иргэнийг эрүүлжүүлсэн.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг “Бласт”, “Мера”, “Ти Эм Би Эн”, “Монтай Эрдэнэ”, “Пауэр бласт”, “Апаменежмент”, “Мон Маг”, “Даваамандал”, “Мөнх тэтгэгч хүч”, “Фоор бласт”,

“Баянмандал”, “Илч түлш”, “Шижир араншин”, “Пироп эрдэнэ”, “Илинкс экспресс”, “Глобал ложистик”, “Максам эксплозивс”, “Си Эм Би” ХХК-тай байгуулсан “Тээвэрлэлтийн хамгаалалтын гэрээ”-ний дагуу 2896 тн 458 кг тэсрэх бодис, 1052624 метр, 1084842 ширхэг тэсэлгээний хэрэгслийг 16 аймгийн 36 сумын нутаг, дэвсгэрт байрлах агуулахад тээвэрлэн хүргэх нийт 176 удаагийн хамгаалалтыг төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэстэй хамтран зохион байгуулсан.

Дөрөв. Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар:

Цагдаагийн байгууллага 2014 оны эхний хагас жилд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 202362 гомдол, мэдээлэл хүлээн авсны 45763 буюу 22.6 хувь нь гэмт хэргийн, 50491 буюу 24.9 хувь нь захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээлэл байсныг шалгаж шийдвэрлэсэн байна. 102696 буюу 50.7 хувь нь утсаар зөвлөгөө өгсөн, газар дээр нь зохицуулсан, саатуулсан, худал дуудлага байсан, харьяаллаар шилжүүлэх байдлаар шийдвэрлэгдэж, 6432 буюу 3.2 хувь нь шийдвэрлэгдээгүй үлдсэн байна.

Улсын хэмжээнд 13565 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 772 хэргээр буюу 6.0, нийслэлд 738 хэргээр буюу 9.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 46.9 хувийг хөнгөн, 44.0 хувийг хүндэвтэр, 7.2 хувийг хүнд, 1.9 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж байна.

Гэмт хэргийн 62.0 хувь нь нийслэлд, 37.5 хувь нь аймгуудад, 0.4 хувь нь Төмөр замын салбарт, 0.1 хувь нь бусад газарт бүртгэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 0.7 хувийг бусдыг санаатай алах, 0.9 хувийг булаах, 1.1 хувийг завших, үрэгдүүлэх, 1.1 хувийг хүчиндэх, 2.9 хувийг дээрэмдэх, 6.0 хувийг залилан мэхлэх, 4.9 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 6.7 хувийг танхайрах, 30.0 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 30.6 хувийг хулгайлах, 15.1 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 6240 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 314.0 хувь, түүнээс 3584 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон нь 23.8 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 57.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.6, нийслэлийн хэмжээнд 56.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар тус тус өсчээ.

Улсын хэмжээнд хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 61.7, хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 52.5, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 65.4, онц хүнд гэмт хэргийн илрүүлэлт 80.9 хувьтай байна.

Гэмт хэргийн улмаас төр, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 38876,7 сая төгрөгийн хохирол учирснаас 15241,3 сая төгрөг буюу 39.2 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлж, 4005,1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Гэмт хэргийн улмаас 502 хүн нас барж, 5139 хүн гэмтсэн нь урьд оны мөн үеэс нас барсан хүн 7 буюу 1.4 хувиар, гэмтсэн хүн 583 буюу 15.3 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэрэгт 11308 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 6.7 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 14.9 хувь нь эмэгтэй хүн эзэлж байгаа өмнөх оны мөн үеэс 0.5 нэгжээр өсч, 5.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 0.7 нэгжээр буурсан байна.

Насны ангиллаар авч үзвэл, 15 хүртэлх насны 168, 16-17 насны 477, 18-24 насны 2891, 25-29 насны 2351, 30-34 насны 1779, 35-39 насны 1339, 40-44 насны 958, 45-49 насны 671, 50-54 насны 392, 55-59 насны 190, 60-64 насны 48, 65-69 насны 22, 70 ба түүнээс дээш насны 22 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байна.

2014 оны эхний хагас жилд 356927 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17640 буюу 4.7 хувиар, зөрчил гаргасан 328257 иргэн бүртгэгдсэн нь 21711 буюу 6.2 тус тус буурсан байна.

Зөрчил гаргасан 328257 иргэн, 23 албан тушаалтан, 652 аж ахуйн нэгж, байгууллагыг 2762213.2 сая төгрөгөөр торгож, 19181 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 8814 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан байна.

Захиргааны зөрчлийн гаралт 139510 буюу 39.1 хувь нь аймгуудад, 79459 буюу 22.3 хувь нь нийслэлд, 131917 буюу 37.0 хувь нь Замын объектод, 5433 буюу 1.5 хувь нь төмөр замд, 608 буюу 0.1 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

Захиргааны хариуцлагын тухай хуулиар 30121 иргэн, 7 албан тушаалтан, 175 аж ахуйн нэгж, байгууллагад 62164 сая, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар 995 иргэн, 11 албан тушаалтан, 471 аж ахуйн нэгж, байгууллагад 181.6 сая, Тамхины хяналтын тухай хуулиар 907 иргэн, 1 байгууллага, аж ахуйн нэгжид 50.3 сая, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 89 иргэн, 5 албан тушаалтан, 5 аж ахуйн нэгж, байгууллагад 3.2 сая, Галт зэвсгийн тухай хуулиар 100 иргэнд 1.3 сая, Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулиар 8 иргэнийг 340.0 мянган төгрөгийн торгууль оногдуулж, 27 иргэнийг шүүхээр баривчлуулжээ.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 64213 хүн саатуулагдсанаас 34457 буюу 53.7 хувь нь нийслэлд, 27907 буюу 43.5 хувь нь аймгуудад, 1849 буюу 2.8 хувь нь Төмөр замын салбарт байна. Саатуулагдсан иргэдийн 3334 буюу 5.2 хувь нь эмэгтэй, 410 буюу 0.6 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байна.

Тав. . Санхүү, аж ахуйн ажлын талаар:

Цагдаагийн байгууллагын 2014 оны нийт зардалд 131.4 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд 2014 оны 05 дугаар сард төсөвт тодотгол хийж 2.9 тэрбум төгрөгийг танаж, 128.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн.

Төсөв төвлөрүүлэн захирагчийн эрх мэдлийн хүрээнд төсвийн гүйцэтгэлд харьцуулалт хийн, тээвэр шатахуун, дотоод албан томилолт, хоол, холбоо, суваг ашигласны түрээс, сургалт дадлага, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, харуул хамгаалалтын зэрэг зардлаас нийт 2.0 тэрбум, цалингийн зардлаас 900.0 сая төгрөгийг танаж, тодотголд оруулсан.

Цагдаагийн алба хаагчийн гадаад үзэмжийг дээшлүүлж, цаг уурын онцлог байдалд тохирсон, алба үүргээ гүйцэтгэх нөхцөлийг хангасан цагдаагийн шинэ дүрэмт хувцасны загварыг боловсруулан, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр батлуулж, нэг ээлжийн хувцасыг захиалан хийлгүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2014 оны эхний хагас жилд өдөр тутмын хар хөх өнгийн ханцуйтай цамц 8000, саравчтай даавуун малгай 8000, дан өмд 8000, ханцуйн бэлэгдэл, энгэрийн тэмдэг тус бүр 18200, савхин дээл 35 ширхэг, өвлийн дотортой гутал 2000, мөрдөс 20100 хос, тоногтой суран бүс 8000 ком зэрэг нийт 930.1 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлж, цагдаагийн алба хаагчдад тавьж олгосон.

Цагдаагийн алба хаагчдын өвлийн дүрэмт хувцасны гадна талын материал бэлтгэх зорилгоор ОХУ-ын Чайковский даавууны үйлдвэр, БНСУ-ы “HANKOOK TEXTILE” компаниас 10000 метр даавууг метр нэг бүрийг нь 11528 төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулсан.

Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй 60 буюу түүнээс дээш жил ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшил олгох ажлыг зохион байгуулан 270 алба хаагчийн судалгааг гаргаж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 324 дүгээр тушаалаар нийт 9 аймгийн 67 алба хаагчдад 728.0 сая төгрөгийн урамшуулал олгосон.

Зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай Нийслэлийн цагдаагийн газрын Замын цагдаагийн газрын “Хаалттай дэд өртөө”-ний төлбөр болох 289,0 сая, Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн хэлтсийн дутуу баригдсан барилгыг дуусгахад шаардагдах 349,0 сая төгрөгийн санхүүжилтийг төсвийн урамшууллаас олгосон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 онд 17 аймгийн 23 сумдад тус бүр нь 78,2 сая төгрөгийн өртөг бүхий цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр /кобан/-ыг 1.8 тэрбум төгрөгөөр барихаар төлөвлөсөн ба өнөөдрийн байдлаар 21 сумын барилгын ажлын гэрээ хийгдэж, 19 сумдын барилгын ажлын гүйцэтгэл 20-30 хувьтай, Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр, Цагаан-Уул сумдын барилгыг Улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.

Санхүүжигдэх ёстой нийт хөрөнгө оруулалтаас гүйцэтгэгч байгууллагуудад 159,6 сая төгрөгийн санхүүжилт олгож, 32,3 сая төгрөгийн санхүүжилтийн эрх нээлгэхээр холбогдох материалыг Хууль зүйн яаманд хүргүүлээд байна.

2014 оны улсын төсөвт автомашин худалдан авах 1.300.0 сая төгрөг батлагдсан тул эхний ээлжинд ОХУ-д үйлдвэрлэсэн УАЗ-2206, УАЗ-31514, Япон улсад үйлдвэрлэсэн Ланд круйзер-200, БНСУ-д үйлдвэрлэсэн Хьюндэй Элентра, Соната-7, Азера маркийн 6 төрлийн 33 ширхэг автомашиныг худалдан авч, Дорнод, Хэнтий, Булган, Сүхбаатар, Архангай, Ховд, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн цагдаагийн газарт олгохоор шийдвэрлэсэн.

2014 онд аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтсийн эрүүлжүүлэх, баривчлах байрны хяналтын камер, агааржуулалтын системийг сайжруулан шинэчлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах ажлын хүрээнд нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг дэх

цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Багахангай, Налайх дүүргийн цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх /баривчлах/ байрны хяналтын камерыг шинэчлэх 82.605.000 /Наян хоёр сая зургаан зуун таван мянга/ төгрөгийн санхүүжилтийг “Архидан согтуурахтай тэмцэх сан”-гаас шийдвэрлүүлэх зорилгоор гэрээ, төсвийн задаргаа, үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Алба хаагчдыг орон сууцжуулах ажлын хүрээнд Баянзүрх дүүрэгт 340, Налайх дүүрэгт 36, Булган аймагт 24 айлын орон сууцыг улсын комисст хүлээлгэн өгч, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг гаргуулж алба хаагчдад олгосон.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлагын шийдвэрээр Баянзүрх дүүргийн 2 хорооны нутаг дэвсгэрт “HERO” констракшны барьж буй орон сууцнаас 4 ихэр хүүхэдтэй болсон Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын Хэрх тосгоны хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Ч.Баттулгад Баянзүрх дүүргийн 2 хорооны нутаг дэвсгэрт 2 өрөө байр олгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын автобаазын алба хаагчдын захиалгаар Хан-Уул дүүрэгт 308 айлын орон сууц барих ажлыг 2014 оны 04 дүгээр сараас эхлүүлсэн ба Хэнтий, Дорнод, Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрууд хөнгөлттэй нөхцөлөөр орон сууц бариулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Зургаа. Дүгнэлт, зорилт:

Цагдаагийн байгууллага 2014 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэх арга хэмжээ авч, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах үүргээ зохих ёсоор биелүүлэн ажиллав.

Цаашид 2014 онд хийж, гүйцэтгэхээр төлөвлөгдсөн арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР